

УАНС НЭЗСС – Бүсийн – Монгол Улс – ХасЛизинг

Улс:	Монгол Улс
Төслийн дугаар:	51706
Бизнесийн салбар:	Санхүүгийн түрээс
Мэдээллийн төрөл:	Хувийн
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн байгууллага
Захирлуудын зөвлөлд танилцуулах тов:	2020 оны 6-р сарын 02
Төлөв:	Батлагдсан
Төслийн товч танилцуулга Англи хэл дээр нийтэлсэн огноо:	2020 оны 6-р сарын 11

Төслийн танилцуулга

Уур Амьсгалын Ногоон Сан (“УАНС”) – Ногоон Эдийн Засгийг Санхүүжүүлэх Үйлчилгээ (“НЭЗСҮ”) - Бүсийн санхүүжилтийн хүрээнд ХасЛизинг ХХК-д 4 сая ам.доллар хүртэлх хамтарсан зээл олгоно. Үүнээс 3 сая ам.доллар хүртэлх хэмжээний эх үүсвэрийг Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (“ЕСБХБ”) үлдсэн 1 сая хүртэлх хэмжээний эх үүсвэрийг УАНС тус тус санхүүжүүлнэ.

Төслийн зорилго

Энэхүү зээл нь НЭЗСҮ-ээс Монгол Улсад хэрэгжүүлэх стандарт болон тайлагнах шаардлагуудын дагуу, дотоодын аж ахуйн нэгжүүдэд уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй технологи нэвтрүүлэх хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зориулагдана. Нийт зээлийн 100% нь Ногоон Эдийн Засгийн Шилжилт-д хамрагдана.

Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн нөлөөллийн дүн 65

Энэхүү төсөл нь санхүүгийн түрээсд тохирсон уур амьсгалын өөрчлөлтийг багасгаж дасан зохицох чадвартай технологийг сурталчилна. Ингэснээр уур амьсгалд ээлтэй технологийг зах зээлд нэвтрэх хурдцыг нэмэгдүүлж Ногоон Шилжилтийн Нөлөөллийн чанаруудыг дэмжинэ. Үүний үр дүнд байгаль орчинд тогтвортой, нүүрстөрөгч ялгаруулалт бага, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засагт шилжих үйл явцыг дэмжинэ.

Харилцагчийн мэдээлэл

ХасЛизинг ХХК

ХасЛизинг ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдсан Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн түрээсийн 2 дахь том аж ахуйн нэгж бөгөөд 2013 оноос хойш ЕСБХБ-тай хамтран ажиллаж байна.

ЕСБХБ-ны санхүүжилтийн дүн

ЕСБХБ-ны санхүүжилт 3,000,000.00 ам.доллар (ам.доллар эсвэл түүнтэй дүйцэх төгрөг)

Төслийн нийт өртөг

Төслийн нийт өртөг 4,000,000.00 ам.доллар

Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн хураангуй

Ангилал - Санхүүгийн байгууллага. ХасЛизинг ХХК нь ЕСБХБ-ны Байгаль Орчин Нийгмийн Үйл Ажиллагааны шаардлагыг хангасан харилцагч байгууллага юм. ХасЛизинг ХХК нь Үйл Ажиллагааны шаардлагын 2, 4, 9 дүгээр зүйлийн нөхцлийг тогтмол хангаж, байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны тайланг жил тутам тайлагнана.

Техникийн хамтын ажиллагаа

Уг төсөл нь Уур Амьсгалын Ногоон Сан – Ногоон Эдийн Засгийг Санхүүжүүлэх Үйлчилгээ - Бүсийн төсөлд багтсан техникийн хамтын ажиллагаа болон УАНС-ын 1 сая ам.доллар санхүүжилтийн үр шимийг хүртэнэ.

Нэмэлт

Уур амьсгалын өөрчлөлтийг багасган дасан зохицох зориулалттай урт хугацааны дотоод валютын санхүүжилтийг ялангуяа COVID-19 цар тахлын нөлөөллөөс шалтгаалан гадаад улсаас Монгол Улс руу чиглэх санхүүжилт татарсан, эрсдэл өндөртэй хөгжиж буй зах зээлээс хөрөнгөө татаж байгаа үед нийлүүлэх.

ХасЛизинг ХХК болон түүний харилцагчид техникийн дэмжлэг авч технологи сонголтын платформын туслалцаатайгаар үйл ажиллагааны стандартаа сайжруулна.

ААН-ийн холбоо барих мэдээлэл

Г. Тамир
info@xacleasing.mn
+976 7011-2061
www.xacleasing.mn
ХасЛизинг цамхаг, 5-р давхар, 1-р хороо, Бага тойруу, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15170,
Монгол Улс

Бизнесийн боломжууд

Бизнесийн боломжууд болон худалдан авах ажиллагааны талаар харилцагч компанитай холбогдоно уу.

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээллийг [EBRD Procurement](#) вэбсайтнаас авна уу:

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа, үйл ажиллагаатай холбоотой асуулт

ЕСБХБ-ны төслүүдийн худалдан авах ажиллагаанаас бусад асуудлаар лавлагаа мэдээлэл авах хаяг:

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)

Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ) нь ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааны талаархи олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс мэдээллийг хэрхэн ил болгох, оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөж ажиллах журмыг тодорхойлдог. Төрийн хэвшлийн захирлуудын зөвлөлийн тайлан илтгэл авах хүсэлтийг хэрхэн гаргах талаарх мэдээллийг доорх холбоосоор ОНМБ-ын вэб хуудсанд хандан авна уу.

Төслийн Гомдлын Газар (ТГГ)

Төслийн Гомдлын Газар (ТГГ) нь ЕСБХБ-ны эгэх хариуцлагын механизм, арга хэрэгсэл юм. Энэ нь ЕСБХБ-ны санхүүжилттэй төслүүд байгаль орчинд буюу нийгэмд хор хохирол учруулсан эсвэл учруулж болзошгүй гэж үзсэн хувь хүн болон байгууллагын зүгээс гаргасан гомдлыг хараат бусаар хянан үзэх боломж олгодог.

Гомдол хэрхэн гаргах талаар мэдээлэл авахыг хүсвэл [Project Complaint Mechanism](#) вэб хуудсанд хандана уу. ТГГ-ын ажилтан (pcm@ebrd.com) гомдол гаргах, гомдлын бүртгэл ба шаардлагын шалгуурт хэрхэн нийцүүлэх тухай асуудлаар таны аливаа асуултанд **ТГГ-ын Үйл ажиллагааны журам -ын** дагуу хариулахад бэлэн байна.